

2018 ОНЫ 8 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2018 оны 8 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ амбулаторийн үзлэг 104, УГТЭ 95, УХТЭ 172 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулахад УХТЭ 52, УГТЭ 59 тохиолдлоор хүлээлгийн тоо буурч, УНТЭ-ийн хүлээгдэл 8 тохиолдлоор нэмэгдсэн байна.

УНТЭ-ийн амбулаторийн 7 кабинетэд нийт 104 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж, өмнөх сарын хүлээгдлээс 8 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Мэс засал 1
- Нүдний даралт 15
- Булчирхай 1
- Булчирхайн мэс засал 11
- Урологи 1
- Хоол боловсруулах эрхтэн судлал 72
- Цус судлалын кабинетэд 1 үйлчлүүлэгч, тус бүр 1-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна. 15 кабинет хүлээгдэлгүй ажиллажээ.

УХТЭ-т нийт 10 кабинетэд 172 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байгаа нь өнгөрсөн сарынхаас 52 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Бөөр судлал 15
- Зүрх судас 38
- Уушиг 14
- Мэс засал 3
- Мэдрэл судлал 15
- Нүд 13
- Булчирхай 11
- Урологи 1
- Хоол боловсруулах эрхтэн судлал 45
- Эмэгтэйчүүдийн кабинетэд 17 үйлчлүүлэгч тус тус 1-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетэд 247 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УГТЭ-т 2 кабинетэд 95 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Бөөр 55, мэдрэл 40 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 59 үйлчлүүлэгчээр буурсан байна. 17 кабинетэд 456 үйлчлүүлэгч буюу 82.7% нь өдөртөө үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 7 кабинетэд нийт 46 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 64 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:


- Элэг цөс нойр булчирхайн кабинет 14
- Толгой хүзүүний мэс засал 8
- Хими эмчилгээ 1
- Эмэгтэйчүүдийн мэс заслын 9
- Ерөнхий мэс заслын кабинет 6
- Гепатологийн кабинет 2
- Ангиографийн кабинетэд 6 үйлчлүүлэгч тус бүр 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 64 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ нь нийт 19 кабинеттайгаар амбулаторийн үзлэг хийдэг. Үүнээс сэтгэл зүйч, хоол зүйч нь хэвтэн эмчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнд зөвлөгөө өгдөг ба хими-2 кабинет нь амбулаторит давтан үзлэг буюу хяналтын өвчтөнүүдийн үзлэг хийдэг. 8-р сард Ерөнхий хавдар судлал, Эмэгтэйчүүдийн мэс засал-I кабинетийн эмч нар амралттай байсан.

Хүлээгдлийг бууруулах зорилгоор Элэг цөс нойр булчирхайн мэс заслын кабинетийн өдөрт үзэх үзлэгийн нормыг 8 хүн, Химийн кабинетийг 15 хүнээр тус тус нэмэгдүүлсэн Цээжний хөндийн мэс засал-II кабинетийг нэмэлтээр ажиллуулснаар тус кабинетэд хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

ЭХЭМҮТ-ийн мэдрэлийн кабинетэд 35 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 8-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2018 оны 8 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн рентген 268 үйлчлүүлэгч 1-14 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 50 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Рентген зураг 58
- Зүрхний цахилгаан бичлэг 6

- Хэвлийн эхо 130
- Тархины цахилгаан бичлэг 3
- MRI шинжилгээ 7
- Захын судасны ЭХО 5
- Бүдүүн гэдэсний дуран 57 үйлчлүүлэгч оношлуулахаар 3-14 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 195 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 62 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Рентген зураг 51
- Зүрхний цахилгаан бичлэг 22
- Хэвлийн эхо 75
- Нүдний уг 5
- Холтер 1
- Допплерографи 4
- MRI 2 оношлуулахаар 1-6 хоногийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. өдөртөө үйлчлүүлсэн 147 үйлчлүүлэгч байна.


УГТЭ-т оношлуулахаар 151 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Үүнд:

- Рентген зураг 19
- Зүрхний цахилгаан бичлэг 62
- Хэвлийн эхо 58
- Тархины цахилгаан бичлэг 9
- Допплерографи 4 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 109 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ-д анх удаа үзүүлэхээр дугаар авсан 174 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 57 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 79, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 38 үйлчлүүлэгч байна. Үүнд: бүдүүн шулуун гэдэсний дуран 1, ходоодны дуран 26, хэвлийн ЭХО 9, зүрхний цахилгаан бичлэг 33 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Рентген аппарат эвдэрсэн тул оношлогоо хийгдээгүй байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 226 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 113 өдөртөө, 2 үйлчлүүлэгч 1 хоног, 9 үйлчлүүлэгч 2 хоног, 54 үйлчлүүлэгч 3-6 хоног, 48 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн оношлогооны кабинетийн 8-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



**СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний
6, 7, 8-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/**



**Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
лабораторийн шинжилгээний хүлээгдэл:**

2018 оны 8 дугаар сард УНТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн. УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 584 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд:


- Цусны ерөнхий шинжилгээ 60
- Шээсний ерөнхий шинжилгээ 52
- Биохимийн шинжилгээ 414
- Бактериологийн шинжилгээ 28
- Иммунологийн шинжилгээ 18
- Коагулаграммын шинжилгээ 8
- Дох/сериологи 4 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 410 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 457 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Цусны ерөнхий шинжилгээ 70
- Биохимийн шинжилгээ 110
- Коагулаграммын шинжилгээ 5 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Иммунолог, серологи, цитологи, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй. Өдөртөө үйлчлүүлсэн 272 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 8-р сарын
хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2018 оны 8 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн. ЭХЭМҮТ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УНТЭ-т 8-р сард нийт 32 үйлчлүүлэгч 1 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Урологийн тасагт 8, эрүү нүүрний мэс заслын тасагт 3, чих хамар хоолойн тасагт 13, хоол боловсруулах тасагт 5, дотоод шүүрлийн тасагт 3 үйлчлүүлэгч байна.

УХТЭ-т 8-р сард 164 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-30 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Үүнд: Зүрх судасны тасаг 26, мэс засал 117, бөөрний тасаг 6, хоол боловсруулах эмгэг судлалын тасаг 9, мэдрэлийн тасагт 6 үйлчлүүлэгч тус бүр 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 8-р сард нийт 97 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөрний тасаг 2, чих хамар хоолойн тасагт 55, мэдрэлийн мэс засалд 31, хоол боловсруулах эмгэг судлалын тасаг 9 үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 8-р сард нийт 269 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 46 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 59 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 81 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 73 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг. Хэвтэх

яаралтай шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 25 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хугацаанд 81 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хугацаанд 14 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 80 үйлчлүүлэгч буюу нийт 200 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

1- 8 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/:



Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 130, мэдрэл 40, Чингэлтэй дүүргийн дотор 82, Наркологийн төв 31 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 8-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХ Д ЭМ Т	ХУ Д ЭМ Т	ЧД ЭМ Т	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг
Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	42	2	0	0	19	28	0	0	6	0	0
	1-3 хоног	8	2		9		3			6		
	3-6 хоног	6			4	10	8					
	7-14хоног	3				9	17					
	15-30 хоног	25			5							

	1 сараас дээш											
Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	141	51	90		10	27	6	0	3	0	0
	1-3 хоног	16	21	50	32		6	6		3		
	3-6 хоног	48	16	25	12	6	8					
	7-14хоног	48	14	15		4	13					
	15-30 хоног	29		0	20							
	1 сараас дээш											
Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	44	0	0		0	8	0	0	0	0	0
	1-3 хоног	15			0		6					
	3-6 хоног	29					2					
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											
Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-3 хоног											
	3-6 хоног											
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											
Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-3 хоног											
	3-6 хоног											
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											


Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	114
	1-3 хоног											32
	3-6 хоног											58
	7-14хоног											22
	15-30 хоног											2
	1 сараас дээш											0

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 8 дугаар сард 28368 дуудлага бүртгэгдсэний 40.1 %-ийг 0-20 минутад, 31.1 %-ийг 21-40 минутад, 15.5%-ийг 41-60 минутад, 13.3%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 8 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/

№	Үзүүлэлт		8 сар	
			Дуудлагын тоо	Хувь
1	Нийт дуудлага		28368	100%
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	11387	40.1
3		21-40 минут	8818	31.1
4		41-60 минут	4396	15.5
5		1 цагаас дээш	3767	13.3

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны сүүлийн 4 сарын хүлээгдлийн мэдээг графикаар харуулахад:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА

